



ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2018 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: **Монголбанкны орон нутаг дахь хэлтэс, салбаруудад агааржуулагч /эйр кондишн/ нийлүүлэх**

Тендер шалгаруулалтын дугаар: **Б -2018/5**

Монголбанк эрх бүхий тендерт оролцогчоос агааржуулагч /эйр кондишн/ нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50,000 (тавин мянга) төгрөгөөр худалдан авч болно. Тендерийн баримт бичгийн үнийг Монголбанкны 4101000014 тоот дансанд (дансны нэр: тендерийн хороо) тушаана. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна:

Борлуулалтын хэмжээ: Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 80 хувиас багагүй байна

Санхүүгийн тайлан ирүүлэх жил: Сүүлийн 2 жил буюу 2016 2017 онуудын жилийн эцсийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан.

Тендерийн хамт тендерт оролцохоор санал болгох үнийн дүнгийн 2 хувьтай тэнцэх дүнтэй тендерийн баталгааг багц тус бүрт ирүүлнэ. Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй бөгөөд тендерт оролцогчид давуу эрхийн зөрүү тооцохгүй болно. Хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрөхгүй.

Тендерийг 2018 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2018 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 10 цаг 40 минутад нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

МОНГОЛБАНК

Бага тойруу-3, 15160, Улаанбаатар хот,
Монголбанкны “Өргөтгөл” байрны 2 дугаар давхар, 37 тоот өрөө,
Утас: (976-11) 311039, факс: (976-11) 311471